



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 233

Улаанбаатар хот

Үнэт цаасыг нийтэд санал болгохыг
зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасах
тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ундрага-Өмнөговь” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 94,775 /ерэн дөрвөн мянга долоон зуун далан тав/ ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

2. Хувьцаагаа компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгийг нэгж хувьцаанд 1,394 /нэг мянга гурван зуун ерэн дөрөв/ төгрөгөөр тооцон “ҮЦТХТ” ХХК-д гэрээ байгуулан төвлөрүүлж, хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх нөхцөлөөр хангахыг “Ундрага-Өмнөговь” ХК /Ж.Энхчимэг/, “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

3. Компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болох шийдвэр гарсантай холбогдуулан өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүнд ногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болохыг дурдсугай.

4. Энэ тогтоолын 3-т заасан хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчийг өөрчлөн байгуулагдаж байгаа хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэж авах үүргийг тухай бүр хэрэгжүүлэхийг “Ундрага-Өмнөговь” ХК /Ж.Энхчимэг/-д даалгасугай.

5. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН